



ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2024 оны 01 сарын 31 өдөр

Дугаар 1/24

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. “Мөнгөлөг шагшуурга-2024” цас, мөсний баярын арга хэмжээг олон нийтэд хүргэх, Соёлын өвийг сурталчлах зорилгоор зохион байгуулсан мэргэжлийн гэрэл зургийн уралдааныг шалгаруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Б.Даваадорж (Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)

Гишүүд: Х.Алтантуяа (Засаг даргын Тамгын газрын Хэвлэл, мэдээллийн ажилтан)

Б.Аюурзана (Аймгийн урчуудын эвлэлийн тэргүүн)

Б.Уртнасан (Соёл, урлагийн газрын соёлын өв хариуцсан мэргэжилтэн)

П.Баяржаргал (Ховд телевизийн найруулагч, зөвлөх)

Нарийн бичгийн дарга: Г.Жавзанхорлоо (Засаг даргын Тамгын газрын Соёл, урлаг, спорт, соён гэгээрлийн асуудал хариуцсан мэргэжилтэн)

2. Ажлын хэсгийн гишүүдийг удирдлага арга зүйгээр хангаж, уралдааныг үр дүнтэй шалгаруулан тайлагнахыг ажлын хэсгийн ахлагч (Б.Даваадорж)-д даалгасугай.

ДАРГА

Б.САНДАГСҮРЭН